МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

# АРХИВЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

("Төрийн мэдээлэл", 2003 он, №02)

1 дүгээр зүйл.Архивын тухай хуулийн 10 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

“10.3.Үндэсний архивын газрын даргыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1-д заасны дагуу нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонгож, эрхлэх асуудлын хүрээнд нь архивын байгууллага хамаарч байгаа Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар томилж, чөлөөлнө.”

2 дугаар зүйл.Архивын тухай хуулийн 16.1, 16.3-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“16.1.Үндэсний төв архивын захирлыг эрхлэх асуудлын хүрээнд нь архивын байгууллага хамаарч байгаа Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн Үндэсний архивын газрын дарга томилж, чөлөөлнө.”

2/16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“16.3.Аймаг, нийслэлийн архивын эрхлэгчийг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн Үндэсний архивын газрын дарга томилж, чөлөөлнө.”

3 дугаар зүйл.Архивын тухай хуулийн 17.2-ын “төвлөрсөн болон орон нутгийн” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Архивын тухай хуулийн 9.3.2-ыг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР